

Ээлжит хичээлийн сэдэв: Жинхэнэ
нэрийн хамаатуулах нөхцөл
Ээлжит хичээлийн зорилго:
Хамаатуулах нөхцөлийг найруулгад
зөв хэрэглэх

Нэгж хичээлийн сэдэв: Жинхэнэ нэр

Онолын ойлголтыг дэвтэртээ тэмдэглэж аваарай.

Хамаатуулах нөхцөл: Тухайн хүн, амьтан, юмс үзэгдлийг төрлийнх нь олон юмны дотроос ялгахын зэрэгцээгээр хэнд, юунд хамаатай болохыг жинхэнэ нэрийн хамаатуулах ёс гэнэ. Хамаатуулах нөхцөлийг биед хамаатуулах, эзэнд хамаатуулах гэж хоёр ангилна. Эзэнд хамаатуулах нь –аа, -ээ, -оо, -өө нөхцөлөөр, биед хамаатуулах нь минь, маань, (1-р бие), чинь, тань (2-р бие), нь (3-р бие) нөхцөлөөр тус тус илэрнэ.

Дараах эхийн хэсгийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Хөвсгөл далай (өгүүллэгийн хэсгээс)

Би Хөвсгөл далай ээжийнхээ торгон эрэг дээр зогсож байна.

Их давлагаан ирж, санаа алдах мэт болоод чимээ тасарна. Далай минь, бүлээхэн тунгалаг ус чинь нялх багын минь нулимсыг санагдуулах чинь юу билээ.

Эрх багын гомдол баярын нулимсаа энд унагаасан юм биш байгаа. Элэг дотно энэ их ус чинь ч гэсэн эцэг өвгөдийн минь нулимс биш байгаа. Эдүгээ бид чинь “Эрдэнэ болсон далай ижий минь” гэж энхрий хайрын нулимсаа унагахыг больсон юм биш байгаа...

Дасгал 1: Жинхэнэ нэрийн хамаатуулах нөхцөлийн хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлоорой.

Алхам 1: Дээрх эхэд байгаа хамаатуулах нөхцөлтэй үгсийг ангилаарай.

Эзэнд хамаатуулах нөхцөлтэй үг

.....

.....

.....

Биед хамаатуулах нөхцөлтэй үг

.....

.....

.....

Бичиж тэмдэглэсэн онолын ойлголт дээрээ тулгуурлан хийгээрэй.

Дасгал 1: Жинхэнэ нэрийн хамаатуулах нөхцөлийн хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлоорой.

Алхам 2: Хамаатуулах нөхцөлтэй үгс нь утгаараа хэнийх, юуных болохыг тодорхойлоорой. Цэгийн оронд бичнэ үү.

Би (надад)	Далай ээжид	Бидэнд
далай ээжийнхээ		нулимсаа

Дасгал 1: Жинхэнэ нэрийн хамаатуулах нөхцөлийн хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлоорой.

Алхам 4: Дараах үгсийг тийн ялгал, хамаатуулах нөхцөлөөр хувилгана уу. Ямар тийн ялгалтай үг эзэнд хамаатуулах нөхцөлөөр хувилдаггүйг олоорой.

Нэрлэх		
Харьяалах		ээжийнхээ
Өгөх орших		
Заах		
Гарах		
Үйлдэх	хайраараа	
Хамтрах		
Чиглэх		

Дасгал 1: Жинхэнэ нэрийн хамаатуулах нөхцөлийн хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлоорой.

Алхам 4: Дараах үгсийг тийн ялгал, хамаатуулах нөхцөлөөр хувилгана уу. Ямар тийн ялгалтай үг эзэнд хамаатуулах нөхцөлөөр хувилдаггүйг олоорой.

Нэрлэх		
Харьяалах		ээжийнхээ
Өгөх орших		
Заах		
Гарах		
Үйлдэх	хайраараа	
Хамтрах		
Чиглэх		